

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### **Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)**

Монгол Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд нийт 1,416 хүүхдийн цэцэрлэг<sup>1</sup> үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 878 цэцэрлэг (27 төмөр замын харьяа хүүхдийн цэцэрлэг), хувийн 538 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 62 цэцэрлэг (төрийн 24, хувийн 38) нэмэгдсэн байна. (Хүснэгт 1).

*Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (тоогоор)*

Хичээлийн жил	Цэцэрлэгийн тоо	Өмчийн хэлбэр	
		Төрийн	Хувийн
<b>2013-2014</b>	1,067	764	303
<b>2014-2015</b>	1,177	777	394
<b>2015-2016</b>	1,288	826	462
<b>2016-2017</b>	1,354	854	500
<b>2017-2018</b>	1,416	878	538

Хувийн цэцэрлэгийн 434 буюу 80.7 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бөгөөд хувийн цэцэрлэг өмнөх оноос 38-аар нэмэгдсэн байна. Энэ хичээлийн жилд нийслэлд хувийн цэцэрлэгүүд (27) нэмэгдсэн байна.

Нийт цэцэрлэгийн 46.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод ногдож байгаа бөгөөд өмнөх оноос 0.7 пунктээр өссөн байна.

### **Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, хүүхдийн тоо (өмчийн хэлбэр, ангилал)**

2017-2018 оны хичээлийн жилд 7,808 бүлэг хичээллэж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 316 буюу 4.2 хувиар нэмэгдсэн. (Хүснэгт 2). Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт<sup>2</sup> дунджаар 32.9 байгаа нь өмнөх жилээс 0.4-өөр өссөн байна. Цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 33.4 байна. Төрийн цэцэрлэгт үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 37.0 байгаа бол хувийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 23.1-тэй байна.

*Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг (тоогоор)*

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
<b>2013-2014</b>	6,086	5,110	976	5,177	4,206	971	909	904	5
<b>2014-2015</b>	6,521	5,619	902	5,294	4,403	891	1,227	1,216	11
<b>2015-2016</b>	7,033	6,150	883	5,655	4,783	872	1,378	1,367	11
<b>2016-2017</b>	7,492	6,637	855	5,908	5,055	853	1,584	1,582	2
<b>2017-2018</b>	7,808	6,981	827	6,125	5,300	825	1,683	1,681	2

<sup>1</sup> “Хүүхдийн цэцэрлэг” гэж 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг ойлгоно.

<sup>2</sup> “Бүлэг дүүргэлт” нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

Улаанбаатар хотын үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 34.6 бөгөөд өмнөх оноос 0.3-аар, төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 44.7 буюу 0.2-аар, хувийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 21.1 буюу өмнөх оноос 0.4-өөр тус тус өссөн байна.

Нийт хүүхдийн 2.1 хувь буюу 5,343 хүүхэд Төмөр замын Хэрэг эрхлэх газрын харьяа цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр буурсан байна.

### Хүснэгт 3. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд (тоогоор)

Хичээлийн жил	Тоо	Насны бүлгээр			
		2 хүртэлх	2 нас	3-5 нас	6 нас
2013-2014	193,672	6,560	35,587	149,932	1,593
2014-2015	206,636	8,085	41,453	155,478	1,620
2015-2016	225,388	8,213	46,799	168,723	1,653
2016-2017	243,432	6,948	49,496	185,390	1,598
2017-2018	256,720	7,403	50,888	196,594	1,835

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн 233,015 буюу 90.3 хувь нь цэцэрлэгийн өдрийн, 24 цагийн үйл ажиллагаатай<sup>3</sup> болон энгийн сургалтад хамрагдаж байгаа нь өмнөх оноос 6.0 хувиар өссөн байна.

### Хүснэгт 4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд (тоогоор)

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2013-2014	193,672	167,878	25,794	174,602	148,915	25,687	19,070	18,963	107
2014-2015	206,636	182,957	23,679	181,878	158,405	23,473	24,758	24,552	206
2015-2016	225,388	201,834	23,554	196,639	173,273	23,366	28,749	28,561	188
2016-2017	243,432	219,811	23,621	209,568	185,972	23,596	33,864	33,839	25
2017-2018	256,720	233,015	23,705	220,049	196,371	23,678	36,671	36,644	27

Хувилбарт сургалт<sup>4</sup>-д 23,705 буюу 9.2 хувь нь хамрагдаж байгаа нь өмнөх оноос 0.5 пунктээр буурсан байна. Үүнээс 4,636 хүүхэд ээлжийн бүлэгт<sup>5</sup>, 16,291 хүүхэд нүүдлийн бүлэгт<sup>6</sup>, 2,778 хүүхэд явуулын багшийн<sup>7</sup> үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг эзэмшиж байна.

Цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхдийг бүлгээр нь авч үзвэл: яслийн бүлэгт 2,674 буюу 1.1 хувь, бага бүлэгт 46,950 буюу 20.1 хувь, дунд бүлэгт 53,957 буюу 23.2 хувь, ахлах бүлэгт 59,061 буюу 25.3 хувь, бэлтгэл бүлэгт 59,268 буюу 25.4 хувь, холимог бүлэгт 11,105 буюу 4.8 хувь нь хамрагдаж байна.

<sup>3</sup> "24 цагийн ажиллагаатай" гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хамтралын шийдвэрээр ажлын 5 өдөр тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг болон бүлгийг хэлнэ.

<sup>4</sup> "Хувилбарт сургалт" үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгааг хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

<sup>5</sup> "Ээлжийн бүлгийн сургалт" боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

<sup>6</sup> "Нүүдлийн бүлгийн сургалт" боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

<sup>7</sup> "Явуулын багшийн сургалт" боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдийн 29,493 буюу 11.5 хувь нь малчдын хүүхэд байна.

*Хүснэгт 5. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхэд*

Хичээлийн жил	Тоо	Насны бүлгээр			
		2 хүртэлх	2 нас	3-5 нас	6 нас
2013-2014	29,806	304	3,881	24,892	729
2014-2015	32,734	320	4,701	26,643	1,070
2015-2016	31,977	414	5,482	25,136	945
2016-2017	31,254	387	4,814	25,233	820
2017-2018	29,493	365	4,791	23,549	788

Мөн 1,599 буюу 0.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2,070 буюу 0.8 хувь нь халамж эдэлдэг, 152 буюу 0.1 хувь нь бүтэн өнчин хүүхэд байна.

*Хүснэгт 6. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо*

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
2013-2014	1,368	246	71	242	118	389	302
2014-2015	1,437	242	82	288	119	514	192
2015-2016	1,369	218	81	252	151	390	277
2016-2017	1,513	241	102	282	170	451	267
2017-2018	1,599	274	97	261	198	391	378

Энэ хичээлийн жилд нийт хүүхдийн 71,970 буюу 28.0 хувь нь цэцэрлэгт шинээр элсэн орсон бөгөөд өмнөх оноос 3,103 хүүхэд буюу 4.3 хувиар өссөн байна.

***Ажиллагчид болон багшлах боловсон хүчин***

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 27,172 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 7,745 буюу 28.5 хувийг үндсэн багш нар эзэлж байгаа нь өмнөх онтой ижил байна. Нийт багш, ажиллагчдын тоо өмнөх оноос 1,533 буюу 6.0 хувиар өссөн байна. Багш, ажиллагчдын 22,314 буюу 82.1 хувь нь төрийн цэцэрлэгт, 4,858 буюу 17.9 хувь нь хувийн цэцэрлэгт ажиллаж байгаа нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилчдын тоо аль аль нь нэмэгдсэн байна.

*Хүснэгт 7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагчид*

Хичээлийн жил	Ажиллагчдын тоо	Үүнээс		Төрийн өмч	
		Төрийн өмч	Хувийн өмч	Хот	Хөдөө
2013-2014	21,019	17,986	3,033	5,813	12,173
2014-2015	21,962	18,492	3,470	5,870	12,622
2015-2016	24,179	20,004	4,175	6,698	13,306
2016-2017	25,639	21,085	4,554	7,341	13,744
2017-2018	27,172	22,314	4,858	8,084	14,230

2017-2018 оны хичээлийн жилд нийт ажиллагчдын 11,182 буюу 43.8 хувь нь хотод, 15,280 буюу 56.2 хувь нь хөдөөд ажиллаж байна. Төрийн өмчийн байгууллагад ажиллагчдын 36.2 хувь хотод, 63.8 хувь нь хөдөөд ажиллаж байна.

*Хүснэгт 8. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн болон туслах багш*

Хичээлийн жил	Үндсэн багш	Үүнээс:				Туслах багш
		Бүлгийн	Дуу хөгжмийн	Ээлжийн	Явуулын	
<b>2013-2014</b>	<b>5,895</b>	<b>5,177</b>	<b>530</b>	<b>96</b>	<b>92</b>	<b>5,249</b>
<b>2014-2015</b>	<b>6,158</b>	<b>5,446</b>	<b>568</b>	<b>72</b>	<b>72</b>	<b>5,589</b>
<b>2015-2016</b>	<b>6,833</b>	<b>6,052</b>	<b>639</b>	<b>65</b>	<b>77</b>	<b>6,133</b>
<b>2016-2017</b>	<b>7,302</b>	<b>6,520</b>	<b>657</b>	<b>64</b>	<b>61</b>	<b>6,508</b>
<b>2017-2018</b>	<b>7,745</b>	<b>6,892</b>	<b>741</b>	<b>64</b>	<b>48</b>	<b>6,970</b>

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш өмнөх жилээс 6.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 9. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин*

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
<b>2013-2014</b>	<b>94.0</b>	<b>2</b>	<b>304</b>	<b>3,919</b>	<b>1,318</b>	<b>352</b>
<b>2014-2015</b>	<b>93.6</b>	<b>0</b>	<b>336</b>	<b>4,270</b>	<b>1,157</b>	<b>395</b>
<b>2015-2016</b>	<b>94.8</b>	<b>1</b>	<b>442</b>	<b>4,922</b>	<b>1,112</b>	<b>356</b>
<b>2016-2017</b>	<b>95.7</b>	<b>0</b>	<b>499</b>	<b>5,505</b>	<b>986</b>	<b>114</b>
<b>2017-2018</b>	<b>97.3</b>	<b>0</b>	<b>540</b>	<b>6,097</b>	<b>899</b>	<b>209</b>

2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн 2,285 буюу 29.5 хувь нь 29 хүртэл, 2,409 буюу 31.1 хувь нь 30-39, 2,292 буюу 29.6 хувь нь 40-49, 683 буюу 8.8 хувь нь 50-59, 76 буюу 1.0 хувь нь 60-аас дээш настай байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 97.3 хувь болсон нь өмнөх оноос 1.6 пунктээр өссөн байна.

Нийт үндсэн багшийн 2,517 буюу 32.5 хувь нь мэргэжлийн зэрэгтэй бөгөөд үүнээс 8 зөвлөх, 413 буюу 5.3 хувь нь тэргүүлэх, 2,096 буюу 27.1 хувь нь заах аргач зэрэгтэй багш нар байна. Өмнөх оноос зэрэгтэй багшийн тоо 149 буюу 6.3 хувиар өссөн дүнтэй байна.